

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код:НТАГ-2024/63/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2023 он

“Б энд С аудит” ХХК-ийн захирал Д.Заяажаргал
Утас: 99050268 Цахим хаяг: bcauditllc@gmail.com

Ахлах аудитор: Ц.Жамъянхорол
Утас: 95282528 Цахим хаяг: bcauditllc@gmail.com

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 99075081 Цахим хаяг: bcauditllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 03.15

№

652

танай _____-ны № _____-т

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, зорилтот түвшний төлөвлөгөөг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, толилуулга, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

Байгууллагын дарга ТУЗ-ийн гишүүнд тушаал гарган 2023 оны Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний төлөвлөгөөнд батлагдаагүй гадаад томилолтын зардалд 7,416.0 мянган төгрөг, анхан шатны нотлох баримтгүй 7,777.0 мянган төгрөгийг хүлээн авалтын зардалд тус тус зарцуулсан, өмнөх оны аудитаар өгсөн Сталь Орд ХХК-аас авах 4,177.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант онд 345,195.7 мянган төгрөгийн цахим төлбөрийн и-баримтгүй худалдан авалт хийсэн зэрэг зөрчлүүд нь Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/688 тоот захирамжаар баталсан 2023 оны Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний зардал хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн

аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.2, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5 заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус газрын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ нь тайлант онд НӨХГ-ын даргын 2023 оны А/235 тоот тушаалаар Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хүрээнд Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр бий болсон 16.5 тэрбум төгрөгийн Сэлбэ болон Баянхошуу дэд төвийн хөрсний ус доошлуулах систем, үерийн хамгаалалтын суваг, НӨХГ-ын даргын 2023 оны А/248 тушаалаар Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар болон Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон 6.9 тэрбум төгрөгийн Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн хөрсний ус зайлуулах шугам, үерийн хамгаалалтын сувгийг хүлээн авч санхүүгийн тайланд толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 чиглэл 14 зорилтын хүрээнд 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		12/31/2022	12/31/2023
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,042,510,133.11	1,254,696,089.61
1.1.2	Дансны авлага	4,177,789.95	4,177,789.95
1.1.4	Бусад авлага	130,092,181.81	175,000,000.00
1.1.6	Бараа материал	703,416,069.80	631,520,141.98
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,880,196,174.67	2,065,394,021.54
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	64,269,874,597.87	82,741,685,319.09
1.2.2	Биет бус хөрөнгө	321,504,000.00	321,504,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	64,591,378,597.87	83,063,189,319.09
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	66,471,574,772.54	85,128,583,340.63
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	22,592,655.00	39,932,703.97
2.1.1.3	Татварын өр	14,245,903.36	91,194,969.46
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	374,892,000.00	374,892,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		22,879,901,293.64
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	411,730,558.36	23,385,920,967.07
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	411,730,558.36	23,385,920,967.07
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	84,502,272,373.94	84,502,272,373.94
2.3.2	Хувийн өмч		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	928,987,463.11	928,987,463.11
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	321,504,000.00	321,504,000.00
2.3.10	Хуримтлагдсан ашиг	(19,692,919,622.87)	(24,010,101,463.49)
2.3.11	Эздийн өмчийн дүн	66,059,844,214.18	61,742,662,373.56
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	66,471,574,772.54	85,128,583,340.63

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	6,678,847,382.98	7,856,716,125.52
2	Борлуулалтын өртөг	4,664,305,473.17	7,154,015,528.72
3	хойшлогдсон орлого		1,050,801,644.36
4	Нийт ашиг (алдагдал)	2,014,541,909.81	348,101,047.56
6	Хүүгийн орлого		11,746,330.45
11	Ерөнхий ба удирдлагын зардал	6,435,530,982.67	3,884,730,617.95
13	Бусад зардал	83,087,030.00	84,771,650.00
15	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(11,324,855.56)
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(4,504,076,102.86)	(4,317,181,840.62)
20	Орлогын татварын зардал		

21	Татварын дараах ашиг (алдагдал)	(4,504,076,102.86)	(4,317,181,840.62)
22	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(4,504,076,102.86)	(4,317,181,840.62)
23.3	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
25	Орлогын нийт дүн	(4,504,076,102.86)	(4,317,181,840.62)
26	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	80,008,051,743.90	928,987,463.11	321,504,000.00	(15,188,843,520.01)	66,069,699,687.04
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	Залруулсан үлдэгдэл	80,008,051,743.90	928,987,463.11	321,504,000.00	(15,188,843,520.01)	66,069,699,687.00
4	Бусад дэлгэрэнгүй орлого					-
5	Өмчид гаргасан өөрчлөлт	4,494,220,630.00				4,494,220,630.00
6	Зарласан ногдол ашиг				-	-
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(4,504,076,102.86)	(4,504,076,102.86)
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	84,502,272,373.94	928,987,463.11	321,504,000.00	(19,692,919,622.87)	66,059,844,214.18
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл	84,502,272,373.94	928,987,463.11	321,504,000.00	(19,692,919,622.87)	66,059,844,214.18
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(4,317,181,840.62)	(4,317,181,840.62)
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	84,502,272,373.94	928,987,463.11	321,504,000.00	(24,010,101,463.49)	61,742,662,373.56

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,200,306,144.00	7,401,639,148.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,191,464,969.00	7,390,211,196.36
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	8,551,175.00	8,365,188.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	290,000.00	3,062,763.64
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,135,529,630.52	6,791,709,560.92
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,923,943,229.81	2,119,273,194.03
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	568,241,728.62	663,879,586.35
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,894,092,341.16	1,898,097,547.92
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	53,719,547.45	
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	686,320,342.30	845,947,902.37
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	739,873,582.54	657,209,911.30
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	5,691,905.00	
1.2.9	Бусад мөнгөн зарлага	263,646,953.64	607,301,418.95
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	64,776,513.48	609,929,587.08
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(221,873,571.25)	(423,256,257.58)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	11,746,330.45
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого		11,746,330.45
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	221,873,571.25	435,002,588.03
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	221,873,571.25	435,002,588.03
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(221,873,571.25)	(423,256,257.58)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	26,902,373.00	25,512,627.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	26,902,373.00	25,512,627.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	26,902,373.00	25,512,627.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	26,902,373.00	25,512,627.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(130,194,684.77)	212,185,956.50
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,172,704,817.88	1,042,510,133.11
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,042,510,133.11	1,254,696,089.61

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	2023 он		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1.1	Нийслэлийн зам арчлалт /цэвэрлэгээ/	3,695,454.5	4,334,690.4	(639,235.9)	117.3
	Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээ ашиглалт	1,618,181.8	1,659,571.4	(41,389.6)	
	Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн засвар арчлалт	381,818.2	343,636.4	38,181.8	
3	Авто замын борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний цэвэрлэгээ үйлчилгээ ашиглалт	1,018,181.8	1,009,042.2	9,139.6	
4	Хөрсний ус зайлуулах шугам сүлжээний засвар арчлалт	54,545.5	58,928.6	(4,383.1)	
5	Борооны болон хөрсний ус зайлуулах өргөлтийн насос станцын ашиглалт, засвар үйлчилгээ	345,454.5	373,146.2	(27,691.6)	
6	Мониторингийн цооногийн ашиглалт, засвар үйлчилгээ	95,454.5	103,125.0	(7,670.5)	
7	Үерийн гамшгийн эрсдэл бууруулахад дэмжлэг		686,761.4	(686,761.4)	
1.2	Нийслэлийн авто зам хөгжлийн газрын санхүүжилт	1,363,636.4	1,393,280.0	(29,643.6)	117.3
1	Авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлтийн ажил	1,363,636.4	1,370,086.7	(6,450.3)	
2	Барьцааны авлага		23,193.3	(23,193.3)	
1.3	Нийслэлийн засаг даргын тамгын газар	318,181.8	1,068,311.6	(750,129.8)	335.8
1	ХУД Жаргалантын амны үерийн хамгаалалтын барилга байгууламж ажил	318,181.8	292,048.1	26,133.8	
1.4	Өөрийн орлого	227,272.8	522,596.2	(295,323.4)	
1.5	Бусад орлого		245,789.8	(245,789.8)	
1	Нийт орлогын дүн	5,604,545.5	7,856,716.1	(2,252,170.6)	140.2
2	Зардал			-	
2.1	Цалин	1,899,977.1	2,433,766.8	(533,789.8)	128.1
2.2	Хоол унааны хөнгөлөлтийн зардал	336,380.0	336,380.0	-	100.0
2.3	НДШ 13.5%	324,271.8	359,003.2	(34,731.5)	110.7
2.4	Удирдах зөвлөлийн зардал	44,496.0	44,496.0	-	100.0
2.5	Ашиглалтын зардал	60,234.0	31,705.6	28,528.4	52.6
2.6	Үндсэн хөрөнгийн элэгдэл	4,897,694.9	5,881,104.4	(983,409.5)	120.1

2.7	Түүхий эд материал	1,687,314.9	1,675,724.7	11,590.2	99.3
2.8	Даатгал	22,978.1	24,337.7	(1,359.7)	105.9
2.9	Шатахуун	633,358.2	683,022.8	(49,664.6)	107.8
2.1	Тээвэр	100,000.0	100,000.0	-	100.0
2.1	Тос, тосолгооны зардал	40,798.5	32,242.2	8,556.3	79.0
2.1	Машин механизмын сэлбэг хэрэгсэл	137,140.0	151,540.1	(14,400.1)	110.5
2.1	Хангамжийн материал	25,402.2	25,402.2	-	100.0
2.1	Хөдөлмөр хамгаалал, багаж хэрэгсэл	73,358.0	73,358.0	-	100.0
2.2	Ажлын хувцас	59,980.0	58,832.2	1,147.8	98.1
2.2	Шуудан холбоо	7,996.0	3,786.4	4,209.6	47.4
2.2	Бичиг хэрэг	20,414.4	20,433.1	(18.7)	100.1
2.2	Албан томилолт	15,000.0	28,353.4	(13,353.4)	189.0
2.2	Шагнал урамшуулал	24,200.0	24,200.0	-	100.0
2.2	Тэтгэмж	32,500.0	24,828.0	7,672.0	76.4
2.2	Сургалт	15,700.0	15,500.0	200.0	98.7
2.2	Албан татвар	6,000.0	4,234.4	1,765.6	70.6
2.2	Газрын төлбөр	1,466.2	1,158.9	307.3	79.0
2.2	Нийгмийн арга хэмжээний зардал	38,450.0	38,450.0	-	100.0
2.3	Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх зардал	5,500.0	5,500.0	-	100.0
2.3	Урсгал засвар, засвар үйлчилгээний зардал	40,000.0	5,838.1	34,161.9	14.6
2.3	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	62,000.0	76,954.3	(14,954.3)	124.1
2.3	Гаднын үйлчилгээний зардал	8,000.0	8,000.0	-	100.0
2.3	Бусад зардал	6,000.0	6,000.0	-	100.0
2.3	Эрсдэлийн сан	8,000.0		8,000.0	-
	Нийт зарлагын дүн	10,634,610.0	12,174,152.4	(1,539,542.4)	114.5
3	Татварын өмнөх ашиг	(5,030,064.5)	(4,317,436.3)	(712,628.2)	116.5
5	Цэвэр ашиг алдагдал	(5,030,064.5)	(4,317,436.3)	(712,628.2)	116.5

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,071,535.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Гадаад албан томилолтын зардал 31,326.3 мянган төгрөг олгохдоо шууд зардалд бичсэн, мөнгөн урьдчилгааны тайлан гаргаагүй.	1	31,326.3			1	31,326.3	1	31,326.3				
Дансны бичилт буруу хийн, авлага, өглөгийн данс бууруулсан, элэгдэл буруу байгуулсан, зардал болон өртгийн дансыг хий өсгөсөн, бууруулснаас нийт хөрөнгө болон өр төлбөр ба эзний өмч тус бүрдээ 993,543.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн,	1	993,543.9			1	993,543.9	1	993,543.9				
Тайлант үеийн алдагдал 2,046,664.9 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн	1	2,046,664.9			1	2,046,664.9	1	2,046,664.9				
Дүн	3	3,071,535.1			3	3,071,535.1	3	3,071,535.1				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

Аудитаар нийт 365,088.0 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрснээс 15,193.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4,177.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 345,717.2 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага Тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АШ	Тоо	Дүн
Байгууллагын дарга ТУЗ-ийн гишүүнд тушаал гарган 2023 оны Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшний төлөвлөгөөнд батлагдаагүй гадаад томилолтын зардал гаргасан	1	7,416.0	1	7,416.0								
Анхан шатны баримтгүй, 7,777.0 мянган төгрөгийн хүлээн авалтын зардал гаргаж, үргүй зардал гаргасан байна	1	7,777.0	1	7,777.0								
Өмнөх оны аудит Сталь Орд ХХК-иас авах авлагыг барагдуулах зөвлөмж өгсөн боловч биелэгдээгүй	1	4,177.8			1	4,177.8						
ХХБ-нд хадгаламж нээж дансны гүйлгээг бүрэн бүртгэлд тусгаагүй 6 дугаар сарын 30-аарх үлдэгдлийг хүүгийн орлого болгон бүртгэж, банкны шимтгэлийн зардлыг 3.0 төгрөгөөр дутуу илэрхийлж үлдэгдэл зөрсөн, хүүгийн орлогыг 97.6 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн, мөн банкны зээлийн хүүгийн зардал 420.9 төгрөгийг бүртгэлд тусгаагүй	1	521.5					1	521.5				
Тайлант онд худалдан авалт хийхдээ 345,195.7 мянган төгрөгийн цахим төлбөрийн и-баримт шивүүлээгүй	1	345,195.7					1	345,195.7				
Дүн	5	365,088.0	2	15,193.0	1	4,177.8	2	345,717.2				

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.